



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/226

Чингис хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "а", Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдрлийн хурлын тэмдэглэл, Үнэлгээний хорооны даргын 01 дугаартай зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан бол он Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын санхүүжилтээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн хүрээнд зарласан "Инженерийн хийцтэй худаг барих" тендерт "Ханбулгийн Эх" ХХК-ний тендерийн баримт бичиг "хамгийн сайн" үнэлэгдсэн дүгнэлтийг Үнэлгээний хорооноос ирүүлсэн тул тус аж ахуйн нэгжид гэрээ байгуулах эрх олгосугай.

2. Тендерт шалгарсан "Ханбулгийн Эх" ХХК-тай "Инженерийн хийцтэй худаг барих" ажлын гэрээг тендерийн хүчинтэй байх хугацаанд багтаан байгуулж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан), гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011459